



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Налайх тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:НТАГ-2026/157/НА-СТА-ОНӨҮГ**

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он	Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Г.Нандинжаргал Утас: 7000-7734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Я.Алтанцэцэг Утас: 325093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Платиниум прогресс аудит ХХК-ийн захирал: Ж.Баяртуул Утас:99066015, Цахим хаяг: Auditbalance6015@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026-03-13 № 525  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НАЛАЙХ ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ  
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ Ц.ЭРБОЛ  
ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Налайх тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус газар нь 2025 оны ажилчдын бүтэц орон тоог 127 байхаар тооцсон боловч батлагдсан төсвийн хүрээнд орон тоог хэмнэж 98 орон тоогоор ажилласан байна.

Тайлант оны нийт орлогыг 5,592.6 сая төгрөгөөр, нийт зардлыг 8,412.2 сая төгрөгөөр, 2,819.2 сая төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 5,949.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 7,256.3 сая төгрөгийн зардал гарган 1,306.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Зорилтот түвшнийг оновчтой зөв төлөвлөөгүй, сүүлийн 3 жил алдагдалтай ажилласан байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус газарт Налайх хотын хөгжлийн корпорацаас 269.9 сая төгрөгийн машин, тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 34 зорилтын хүрээнд 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 96.8 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлангийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон.

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Хөрөнгө		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	86,249,406.81	76,496,571.06
1.1.2	Дансны авлага	27,201,400.00	53,996,304.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	109,480,866.00	387,769,023.80
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/Тооцоо		
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	222,931,672.81	518,261,898.86
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	9,451,236,278.45	12,755,281,813.80
1.2.2	Биет бус хөрөнгө	91,225,750.00	91,225,750.00
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	9,542,462,028.45	12,846,507,563.80
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	9,765,393,701.26	13,364,769,462.66
2	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	127,422,668.50	164,770,815.81
2.1.1.3	Татварын өр	253,568,333.72	173,901,166.77
2.1.1.4	НДШ - ийн өглөг	41,027,571.22	58,428,968.05
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүгийн өглөг		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	422,018,573.44	397,100,950.63
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	10,041,406,354.13	14,972,041,106.49
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	10,041,406,354.13	14,972,041,106.49
2.2	Өр төлбөрийн нийт дүн	10,463,424,927.57	10,438,507,304.76
2.3	Эзэмшигчдийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	1,031,531,894.26	1,031,531,894.26
2.3.2	- хувийн		
2.3.3	- Хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,353,362,538.43	1,353,362,538.43
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(3,082,925,659.00)	(3,082,925,659.00)
2.3.10	Тайлант үеийн үр дүн		(1,306,341,368.15)
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	(698,031,226.31)	2,926,262,157.90
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	9,765,393,701.26	13,364,769,462.66

## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон.

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	4,243,355,552.71	5,949,825,245.70
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	1,518,584,882.80	1,765,114,976.96
3	Нийт ашиг (алдагдал)	2,724,770,669.91	4,184,710,268.74
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого		113,188.12
6	Ерөнхий ба удирдлагын зардал	3,864,938,993.90	5,276,263,974.25
7	Санхүүгийн зардал		
8	Бусад зардал	162,260,178.96	214,900,850.76
9	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(1,302,428,502.95)	(1,306,341,368.15)
10	Орлогын татварын зардал		
11	Татварын дараах ашиг (алдагдал)	(1,302,428,502.95)	(1,306,341,368.15)
12	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал		
13	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	(1,302,428,502.95)	(1,306,341,368.15)
14	Орлогын нийт дүн	(1,302,428,502.95)	(1,306,341,368.15)
15	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон.

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2024 оны 1-р сарын 1- ний үлдэгдэл	1,031,531,894.26			1,031,531,894.26
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
2025 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	1,031,531,894.26	1,353,362,538.43	(3,082,925,659.00)	(698,031,226.31)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(1,306,341,368.15)	(1,306,341,368.15)
Бусад дэлгэрэнгүй орлого				
2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,031,531,894.26	1,353,362,538.43	(4,389,267,027.15)	(2,004,372,594.46)

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон.

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	4,371,497,536.71	5,978,273,392.47
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		
	Татаас, санхүүжилтийн орлого	3,306,776,020.00	4,764,340,100.00
	Бусад мөнгөн орлого	1,064,721,516.71	1,213,933,292.47
1.2	Мөнгөн зарлага (-)	4,291,181,737.02	5,947,362,251.88
	Ажиллагчдад төлсөн	1,591,775,861.00	2,413,568,220.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	421,871,800.00	740,651,189.00

	Бараа материал худалдан авахад төлсөн	264,372,828.00	627,586,257.00
	Ашиглалтын зардалд төлсөн	20,358,334.44	50,002,105.21
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,170,876,483.40	1,275,661,827.00
	Хүүгийн төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	281,268,730.75	326,322,291.35
	Даатгалын төлбөрт төлсөн	0.00	1,830,600.00
	Бусад мөнгөн зарлага	540,657,699.43	511,739,762.32
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	80,315,799.69	30,911,140.59
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	726,154.69	108,723.66
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Хүлээн авсан хүүгийн орлого	0.00	108,723.66
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	4,499,900.00	40,772,700.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	4,499,900.00	40,772,700.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(4,499,900.00)	(40,663,976.34)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	75,815,899.69	(9,752,835.75)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,433,507.12	86,249,406.81
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	86,249,406.81	76,496,571.06

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон.

/төгрөгөөр/

	ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны гүйцэтгэл	2025 оны төлөвлөгөө	2025 оны гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	НИЙТ ОРЛОГО	4,243,355,552.71	5,592,585,840	5,949,938,433.82	358,352,593.82	6.3
1	Санхүүжилт	3,306,776,020	4,095,571,400	4,285,571,500	190,000,100	4.4
2	Ногоон байгууламж арчлалт		478,768,600	478,768,600	-	
3	Хогийн цэгийн дарж булах санхүүжилт	312,998,280	468,135,840	444,091,780	(24,044,060.)	5.4
4	Бусад орлого	619,177,852.71	550,000,000	741,393,365.70	191,393,365.70	25.8
5	Хүүгийн орлого		110,000	113,188.12	3,188.12	2.8
6	Түрээсийн орлого	4,403,400				
	УДИРДЛАГЫН ЗАРДАЛ	474,303,056.18	577,410,260	692,568,623.25	(115,158,363.25)	
7	Цалин	333,532,524	381,540,000	384,787,522	(3,247,522)	0.84
8	НДШ,	39,652,000	49,600,200	46,516,393	3,083,807	6.6

9	Бичиг хэргийн материал	5,391,234	7,786,000	8,914,450	(1,128,450)	12.6
10	Дотоод томилолт		3,362,400	2,923,800	438,600	15
11	Гар утас/Шуудан	1,293,200	3,408,000	2,220,137	1,187,863	53.5
12	Засвар үйлчилгээ	10,096,360	35,000,000	35,932,810	(932,810)	2.6
13	Ашиглалт	17,896,989.94	21,014,960	26,398,973.21	(5,384,013.21)	20.3
14	Даатгал	1,411,695	1,558,700	3,493,044	(1,934,344)	55.3
15	Мэргэжлийн үйлчилгээ	6,264,000	11,740,000	14,761,100	(3,021,100)	20.4
16	Татвар	5,793,196	11,020,000	14,413,205.24	(3,393,205.24)	23.5
17	Цэвэрлэгээ үйлчилгээ	733,360	7,880,000	3,965,905.80	3,914,094.20	98.6
18	Буцалтгүй тусламж	18,280,000	15,500,000	35,621,558	(20,121,558)	56.4
19	Сургалтын зардал	2,094,500	-	4,528,000	(4,528,000)	100
20	Үйл ажиллагааны бус зардал	31,863,997.24	28,000,000	108,091,725	(80,091,725)	8.2
ЗАМ ТАЛБАЙН ЦЭВЭРЛЭГЭЭ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,853,866,344.30	3,088,198,740	2,889,844,828.62	198,353,911.38	
21	Цалин	868,455,240	1,197,858,000	1,073,428,094	124,429,906	11.5
22	НДШ	119,425,250	155,721,540	101,625,355	54,096,185	53.2
23	Багаж хэрэгсэл	35,854,200	44,360,000	71,837,900	(27,477,900)	38.2
24	Хөдөлмөр хамгаалал		48,720,000	63,117,300	(14,397,300)	22.8
25	Элэгдэл	1,594,824,328.30	1,022,354,000	1,075,520,100	(53,166,100)	4.9
26	НЭ-ийн зам цэвэрлэгээний зардал	96,668,120	250,000,000	81,705,997.06	168,294,002.94	205.9
27	Нохой устгал	60,792,000	96,000,000	109,464,000	(13,464,000)	12.3
28	НЭ-ийн хөрөнгө засвар	77,847,206	100,000,000	169,146,082.56	(69,146,082.56)	40.8
29	Шатахууны зардал		173,185,200	144,000,000	29,185,200	20.2
ХОГ ТЭЭВРИЙН ЗАРДАЛ		1,871,300,277.78	3,897,426,720	2,970,412,593.10		
30	Цалин	712,958,703.27	2,080,224,000	1,132,268,700	947,955,300	83.7
31	НДШ	83,858,816.15	270,429,120	149,132,369	121,296,751	81.3
32	Багаж хэрэгсэл	25,187,500	37,400,000	5,073,550	32,326,450	637.1

33	Хөдөлмөр хамгаалал	15,367,629.19	69,648,000	33,184,500	36,463,500	109.8
34	Элэгдэл		552,022,200	594,620,617	(42,598,417)	7.1
35	Шатахууны зардал	497,485,916	505,583,400	504,993,750.40	589,649.6	0.12
36	Гэрээний шимтгэл	65,328,729.77	75,600,000	69,662,092.70	5,937,907.3	8.5
37	Хур хог тээвэрлэх зардал	98,474,800	41,020,000	137,052,009	(96,032,009)	70
38	Сэлбэг засвар үйлчилгээ	345,738,183.40	250,000,000	327,925,005	(77,925,005)	23.7
39	Түрээс	26,900,000	15,500,000	16,500,000	(1,000,000)	6.06
	Хог дарж булах зардал	346,314,377.40	370,388,000	253,274,759	117,113,241	
40	Цалин		147,600,000	53,756,427	93,843,573	174.5
41	НДШ, даатгал		19,188,000	6,193,232	12,994,768	209.8
42	Гэрэл цахилгаан	4,985,420	1,500,000	1,455,200	44,800	3.08
43	Шатахууны зардал	270,945,907.40	197,100,000	155,000,000	42,100,000	27.1
44	Хог дарж булах зардал	70,383,050	5,000,000	36,869,900	(31,869,900)	86.4
	Ногоон байгууламж арчлалт -		478,768,600	450,178,998	28,589,602	
45	Цалин		341,604,803	321,604,803	20,000,000	6.2
46	НДШ		55,307,227	46,717,625	8,589,602	18.3
47	Бараа материал		24,456,170	24,456,170	-	
48	Ашиглалтын зардал		15,550,400	15,550,400	-	
49	Шатахууны зардал		41,850,000	41,850,000	-	
50	Нийт зардлын дүн	5,545,784,055.66	8,412,192,320	7,256,279,801.97	1,155,912,518.03	15.9
51	Тайлант үеийн ашиг, алдагдал	(1,302,428,502.95)	(2,819,606,480)	(1,306,341,368.15)		

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 9,846,994.6 мянган төгрөгийн 3 алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулсан. Үүнд:

- Санхүүгийн тайлангийн орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээний тайлангийн өмнөх оны үзүүлэлтүүд, өмчийн өөрчлөлтийн тайлангийн оны эхний үлдэгдлийг 4,631,066.7 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.

- Бараа материалын бэлэн бүтэгдэхүүний төрөлд бэлэн бүтээгдэхүүний шинж чанаргүй 285,293.0 мянган төгрөгийн материалыг бүртгэсэн байна.
- Тус газрын улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгагдсан дүнгээс санхүүгийн тайлан дахь төрийн өмчийн дүнг 4,930,634.8 мянган төгрөгөөр илүү тусгасан байна.

НББОУС1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, MNS-6817-4:2020 стандартын санхүүгийн тайлагналын “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг; 5.2.1.7.2-т “Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх” заалт, санхүүгийн тайлагналын “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Аудитаар нийт 32,091.8 мянган төгрөгийн 4 зөрчил илэрснээс, 24,810.9 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 7,280.9 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Аудитаар илрүүлсэн 32,091.8 мянган төгрөгийн материаллаг залруулагдаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### **3.1 Албан шаардлага**

Тайлант онд 9 ажилтанд ээлжийн амралтыг биеэр эдлүүлээгүй 24,810.9 мянган төгрөгийн цалин давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 99.1 "Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “үнэн зөв байдал”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ээлжийн амралтыг биеэр эдлүүлээгүй, цалин давхардуулан олгосон зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүллээ.

### **3.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал.

*Илрүүлэлт-1:* Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, 1,035.4 мянган төгрөгийг урамшуулалд, 5,980.0 мянган төгрөгийг шинэ жилийн баярын бэлэг дурсгалд, 256.6 мянган төгрөгийг бичиг хэргийн зардалд зарцуулсан байна. Энэ нь МУЕС-ын 2025 оны 05 дугаар албан даалгаврын 1.3-т "Төрийн хэмнэлтийн тухай хуулийг чанд мөрдөж, төсвийн хөрөнгөөр шинэ жил, байгууллагын болон салбарын ой тэмдэглэх зэрэг олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахгүй, бэлэг дурсгалын зүйл бэлтгэхгүй байх" 1.4.2-т "байгууллагын дотоод журмаар олгодог нэг удаагийн тэтгэмж, урамшууллыг түр зогсоох", 1.4.3-т "тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж, бичиг хэргийн зүйлс

худалдан авахгүй байх" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "үнэн зөв байдал", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах, хөтөлбөр, арга хэмжээний зардлуудыг хэмнэх, төсвийн хэмнэлтийг горимыг хэрэгжүүлэх зөвлөмж өгөв.

2. Зорилтот түвшин, эдийн засгийн үзүүлэлттэй холбоотой асуудал.

Илрүүлэлт-1: Зорилтот түвшний төлөвлөгөөг оновчтой зөв төлөвлөөгүй, сүүлийн 3 жил алдагдалтай ажиллаж, тайлант онд алдагдлын хэмжээг 53.6 хувиар бууруулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3-т "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "үнэн зөв байдал", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Зорилтот түвшний төлөвлөгөөг оновчтой төлөвлөх, байгууллагын ашигт ажиллагааг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах зөвлөмж өгөв.

3. Санхүүгийн тайлангийн хугацаатай холбоотой асуудал.

Илрүүлэлт-1: Жилийн эцсийн санхүүгийн тайланг тайлан ирүүлэх хуулийн хугацааг 9 хоногоор хоцроож ирүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 8.9.8-д "Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор Төрийн аудитын байгууллагад хүргүүлж, ...хүргүүлэх" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланг төрийн аудитын байгууллагад хуулийн хугацаанд ирүүлж байх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн тайлангийн орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээний тайлангийн өмнөх оны үзүүлэлтүүд, өмчийн өөрчлөлтийн тайлангийн оны эхний болон эцсийн үлдэгдлийг буруу тайлагнасан.	1	4,631,066.7			1	4,631,066.7	1	4,631,066.7				
Бараа материалын бэлэн бүтэгдэхүүний төрөлд бэлэн бүтээгдэхүүний шинж чанаргүй материалыг бүртгэсэн.	1	285,293.1			1	285,293.1	1	285,293.1				
Тус газрын улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгагдсан дүнгээс санхүүгийн тайлан дахь төрийн өмчийн дүнг 4,930,634.8 мянган төгрөгөөр илүү тусгасан.	1	4,930,634.8			1	4,930,634.8	1	4,930,634.8				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>9,846,994.6</b>			<b>3</b>	<b>9,846,994.6</b>	<b>3</b>	<b>9,846,994.6</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд 9 ажилтанд ээлжийн амралтыг биеэр эдлүүлээгүй, цалин давхардуулан олгосон.	1	24,810.9			1	24,810.9						
Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, 1,035.4 мянган төгрөгийг урамшуулалд, 5,980.0 мянган төгрөгийг шинэ жилийн арга хэмжээнд, 256.6 мянган төгрөгийг бичиг хэргийн зардалд зарцуулсан.	1	7,280.9					1	7,280.9				
Зорилтот түвшний төлөвлөгөөг оновчтой зөв төлөвлөөгүй, сүүлийн 3 жил алдагдалтай ажилласан.	1	0.0					1	0.0				
2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаа хоцроож 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 29 тоот албан бичгээр ирүүлсэн.	1	0.0					1	0.0				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>32,091.8</b>			<b>1</b>	<b>24,810.9</b>	<b>3</b>	<b>7,280.9</b>				